

Авлигатай тэмцэх газар

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2013

Улаанбаатар 2013

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ.....	3
1. Судалгааны зорилго	3
2. Судалгааны арга зүй, түүвэрлэлт.....	3
2.1 Судалгааны арга зүй.....	3
2.2 Түүвэрлэлт.....	3
2.3 Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт ба боловсруулалт	4
БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	5
1. Хүүхдийн шударга байдал 2013 судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтэц	5
2. Хүүхдийн шударга байдал	6
3. Хүүхдийн шударга байдал, дэд үзүүлэлтээр	8
3.1 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ	9
3.2 Хүүхдийн зөв төлөвшлийн үнэлгээ	11
3.3 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдлын үнэлгээ	14
3.4 Авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ	17
ДҮГНЭЛТ	20
САНАЛ.....	21
ХАВСРАЛТ	22

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлсэн асуулт, дугаараар	3
Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр.....	8
Зураг 1. Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцсон хүүхдүүд, хүйсээр	5
Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, ангиар	5
Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр	6
Зураг 4. Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, судалгаа явуулсан оноор.....	6
Зураг 5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин, насаар	7
Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин суралцаж буй ангиар /7-11-р анги/.....	7
Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин аймаг, нийслэлээр	8
Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр	8
Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ	9
Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/	10
Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/	10
Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/	11
Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/	11
Зураг 14. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ.....	12
Зураг 15. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/	13
Зураг 16. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/	13
Зураг 17. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/.....	14
Зураг 18. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ	15
Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/	15
Зураг 20. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/	16
Зураг 21. Хүүхдийн хууль ягштал сахих дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/.....	16
Зураг 22. Хүүхдийн хууль ягштал сахих дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/	17
Зураг 23. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ	18
Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/	18
Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/..	19
Зураг 26. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/...	19
Зураг 27. Хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/ .	20

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1. Судалгааны зорилго

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн зан үйлийн зөв төлөвшил, ёс суртахуун, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг судлах, цаашид шударга бус зүйлтэй эвлэрэхгүй, шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд хийгдэх авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг чиглүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршиж байна юм.

2. Судалгааны арга зүй, түүвэрлэлт

2.1 Судалгааны арга зүй

Судалгааг БНСУ-ын Транспэрэнси интернэшнл байгууллагаас боловсруулан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, БНСУ, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан юм. Манай улс энэхүү аргазүйн дагуу “Хүүхдийн шударга байдал” судалгааг 4 дэх удаагаа зохион байгуулаад байна.

Хүүхдийн шударга байдлын судалгааны асуулга нь нийт 12 асуултаас бүрдэж байгаа бөгөөд Хүснэгт 1-д харуулснаар хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих, авлигыг үл тэвчих байдлыг 3 түвшинд /танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн/ үнэлсэн юм.

Асуулт тус бүрт тухайн хүүхдийн санал нийлж байгаа эсэхийг үнэлүүлсэн бөгөөд шударга байдлын үнэлгээг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн. Шударга байдлын үнэлгээ 5 руу ойртох тусам шударга, 1 рүү ойртох тусам шударга бус гэсэн утгыг илэрхийлнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлсэн асуулт, дугаараар

	Ёс зүй/Ёс суртахуун	Зөв төлөвшил	Хууль ягштал сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

Дээрх хүснэгтийн мөр, багана тус бүрт байгаа үзүүлэлтүүдээр дугаарласан 12 асуулт бүхий асуулгыг хүүхдүүдээр бөглүүлэх замаар судалгааг авсан.

2.2 Түүвэрлэлт

Судалгааны түүврийн хүрээ нь ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангид сурч буй хүүхдүүд бөгөөд сонгогдсон 7 аймаг, нийслэлийн 3 дүүргийн 800 хүүхдийг санамсаргүй байдлаар сонгон авч судалгаанд хамруулсан юм.

Судалгаанд Төв, Баянхонгор, Сүхбаатар, Архангай, Дархан-Уул, Говьсүмбэр, Баян-Өлгий аймаг, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Багануур дүүргийн хүүхдүүд хамрагдав.

2.3 Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт ба боловсруулалт


Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох мэдээллийн эх үүсвэр нь “Хүүхдийн шударга байдал 2013” судалгаа байв. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг АТГ-ын Судалгаа шинжилгээний алба Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгуулж явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажлыг 2013 оны 06 дугаар сарын 15-аас 08 дугаар сарын 28 -ны хооронд хийсэн. “Хүүхдийн шударга байдал судалгаа”-ны мэдээллийг CSPro 5.0 болон Statistics SPSS 21.0 програмыг ашиглан боловсруулав.

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. Хүүхдийн шударга байдал 2013 судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтэц


Хүүхдийн шударга байдлын судалгаанд нийт 800 хүүхдийг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 384 буюу 48.00% нь эрэгтэй, 416 буюу 52.00% нь эмэгтэй байлаа (Зураг 1).

Зураг 1. Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцсон хүүхдүүд, хүйсээр




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ангиар нь авч үзвэл 7 дугаар ангийн сурагч 118 буюу нийт хүүхдийн 14.75%, 8 дугаар ангийн сурагч 144 буюу 18.00%, 9 дүгээр ангийн сурагч 173 буюу 21.63%, 10 дугаар ангийн сурагч 178 буюу 22.25%, 11 дүгээр ангийн сурагч 187 буюу 23.38% байв (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, ангиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг аймаг /судалгаанд хамрагдсан аймгууд/, нийслэлээр авч үзвэл 492 хүүхэд буюу 61.50% нь аймгаас, 308 хүүхэд буюу 38.50% нь нийслэлээс хамрагдсан байна.


Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр



2. Хүүхдийн шударга байдал


Хүүхдийн шударга байдлын түвшинг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлт 2013 онд 3.71 гарсан нь 2010 оныхоос 0.48 пункт, 2012 оныхоос 0.78 пунктээр тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл 2010, 2012 оныхоос хүүхдийн шударга байдлын түвшин нэмэгдсэн байна (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, судалгаа явуулсан оноор




Хүүхдийн шударга байдлын түвшинг мөн хүүхдүүдийн насны ангиллаар тус тус үнэлж Зураг 5-д харуулав. Судалгаагаар 12 настай хүүхдийн шударга байдлын түвшин 3.87 байгаа нь бусад насны хүүхдүүдийнхээс өндөр байсан бол 11 настай хүүхдүүдийн хамгийн бага буюу 3.51 гарсан байна.

Зураг 5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин, насаар



Хүүхдүүдийн шударга байдлыг мөн суралцаж буй ангиар нь авч үзвэл 8 дугаар ангийн хүүхдийн шударга байдлын түвшин 3.79 гарсан нь бусад ангийн хүүхдийнхээс шударга гарсан байна (Зураг 6). Харин 7 болон 11 дүгээр ангийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин бусад ангийн хүүхдүүдийнхээс бага гарсан байна.

Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин суралцаж буй ангиар /7-11-р анги/




Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр авч үзвэл өндөр оноог Дархан-Уул, Говьсүмбэр аймаг авсан байхад бага оноог Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн хүүхдүүд авсан байна (Зураг 7).

Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин аймаг, нийслэлээр



Хүүхдийн шударга байдлын түвшин хүйсийн хувьд мөн харилцан адилгүй байна. Эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 3.73 байгаа нь эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшний 3.69 гэсэн үзүүлэлтээс 0.04 пунктээр илүү байна.

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. Хүүхдийн шударга байдал, дэд үзүүлэлтээр

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих, авлигыг үл тэвчих гэсэн 4 бүлэг дэд үзүүлэлт тус бүрийн хүрээнд үнэлгээ хийв. Ёс зүй, ёс суртахууны дундаж үнэлгээ 2013 онд 3.80, зөв төлөвшлийн дундаж үнэлгээ нь 3.88, хууль ягштал сахихын дундаж 3.83 гарч өмнөх оныхоос өссөн байхад авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.35 гарч өмнөх оныхоос 0.49 пунктээр буурсан байна. Эдгээр дэд үзүүлэлт тус бүрт нь авч үзье.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

Дэд үзүүлэлт	2010	2012	2013
--------------	------	------	------

Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80
Зөв төлөвшил	2.51	2.29	3.88
Хууль ягштал сахих	3.54	2.85	3.83
Авлигыг үл тэвчих	4.10	3.84	3.35


3.1 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ

Хүүхдийн шударга байдал 2013 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээг ёс суртахууны талаарх ойлголт, ёс зүй, суртахуунд нөлөөлөх нөлөөлөл, одоо тус дэд үзүүлэлт ямар түвшинд байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Ёс суртахууны талаарх танин мэдэхүйг нь-Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
- Ёс суртахуунд нөлөөлөх нөлөөллийг-Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл.
- Ёс суртахууны зан үйл нь-Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.


Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ нь 3.80 гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд 2010, 2012 оны дүнтэй харьцуулахад өссөн байгааг зурагт үзүүлэв (Зураг 9).

Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ




Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээг байршлын хувьд авч үзвэл 2013 онд аймгийн хүүхдүүд 3.84 буюу нийслэлийн хүүхдийнхээс 0.04 пунктээр илүү байна. Өмнөх судалгааны дүнгээс хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ байршлын хувьд нэмэгдсэн ч аймгийн хүүхдүүдийн үнэлгээ илүү нэмэгдсэн байна.

Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/




Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээг мөн хүйсээр авч үзвэл эмэгтэй хүүхдүүдийн үнэлгээ 3.81 гарсан нь эрэгтэй хүүхдүүдийнхээс 0.03 пунктээр илүү байна. Өмнөх 2010, 2012 оны судалгаагаар эрэгтэй хүүхдүүдийн ёс суртахууны дэд үзүүлэлт эмэгтэй хүүхдүүдийнхээс илүү байсан бол 2013 онд эмэгтэй хүүхдүүдийнх өндөр болсон байна.

Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/




Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийг мөн нас болон суралцаж буй ангиар нь Зураг 12, 13-т харуулав.

Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/



7-11 дүгээр ангийн хүүхдүүдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ анги бүрт 2012 онд өмнөх оныхоос буурч байсан бол 2013 онд өмнөх оныхоос өссөн дүнтэй гарсан байна.

Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/




3.2 Хүүхдийн зөв төлөвшлийн үнэлгээ

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн зөв төлөвшлийн үнэлгээг дараахь 3 асуултад санал нийлж байгаа эсэхээр нь хариулт сонгуулан тодорхойлсон.

- Зөв төлөвшлийн танин мэдэхүйг нь–ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш
- Зөв төлөвшлийн нөлөөллийг нь–багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга
- Зөв төлөвшлийн зан үйлийг нь–авлига авсан, хулгай хийсэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.

Хүүхдийн зөв төлөвшлийн дундаж үнэлгээ 3.88 гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь өмнөх онуудад гарсан үр дүнгээс ахисан үзүүлэлттэй байна. Хүүхдийн шударга байдал 2013 судалгааны хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийг судалгаанд оролцсон хүүхдүүдийн амьдарч, сурч байгаа байршлаар, хүйсээр, суралцаж буй ангиар, насаар нь тус тус гарган өмнөх судалгааны жилүүд буюу 2010, 2012 онд гарсан дүнтэй харьцуулсан байдлаар үзүүлэв (зураг 14-17).


Зураг 14. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Хүүхдүүдийн зөв төлөвшилд нөлөөлж буй зарим үзүүлэлтийн хувьд цаашид сайжруулах асуудал байсаар байна. Тухайлбал өнөөгийн мөрдөж буй "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм"- д "*Багшлах үүргээ хэрэгжүүлсний төлөө эцэг эхээс шан харамж авах, төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед үнэтэй бэлэг өгөхөөс аргагүй байдалд суралцагчид болон тэдний асран хамгаалагчид, эцэг эхийн зөвлөлийг хүргэхгүй байх*" гэсэн байдлаар тусгасан байгаа нь хэт ерөнхий байгаа юм. Иймд энэ дүрмийг сайжуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.


Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлт байршлын хувьд мөн өмнөх судалгааныхаас өөр хандлагатай гарсан байна. Өөрөөр хэлбэл, нийслэлийн хүүхдүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ аймгийн хүүхдүүдийнхээс өндөр гарч байсан бол 2013 онд аймгийн хүүхдүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ нийслэлийн хүүхдүүдийнхээс 0.39 пунктээр өндөр гарсан байна.

Зураг 15. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/




Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлт суралцаж буй анги болон насны байдлаар мөн өмнөх судалгаануудынхаас өссөн дүнтэй гарсан байна (Зураг 16, 17).

Зураг 16. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/



Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээгээр 18 насны хүүхдүүдийнх хамгийн өндөр буюу 4.03 гарсан байхад ангиар нь авч үзвэл 10 дугаар ангийн хүүхдүүдийнх бусад ангийн хүүхдүүдийнхээс өндөр гарсан байна (Зураг 17).

Зураг 17. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/



3.3 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдлын үнэлгээ


Судалгаанд оролцсон хүүхдүүдийн нийгэмд хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэхэд өөрсдийгөө хэрхэн хянах чадвартайг харуулж буй дэд үзүүлэлтийг хэрхэн илэрч байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Хууль ягштал сахих явдлыг танин мэдэхүй нь-Миний сайн найз шалгалтан дээрээ хуулж болно. Энэ буруу зүйл биш.
- Хууль ягштал сахих явдалд нөлөөлөх нөлөөллийг-Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно.
- Хууль ягштал сахих явдал илэрч буй зан үйл нь-Ойр хавьд цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм зөрчиж болно.

Өсвөр насныхны ихэвчлэн зан байдал төлөвшөөгүй байдаг ба олон нийтээр хүлээн зөвшөөрөн дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журмыг хүндэтгэн дагах явдлыг төлөвшүүлэх нь чухал асуудал юм. Хүүхдийн шударга байдал 2013 оны судалгааны үр дүнгээр энэхүү хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүүхдүүд дагаж мөрдөх, өөрсдийгөө хянах чадварыг илтгэх тус дэд үзүүлэлтийн бүлгийн дундаж үнэлгээ 3,83 байна.


Хүүхдийн шударга байдал 2013 судалгааны хүүхдийн хууль дүрэм сахин биелүүлэх байдлын дэд үзүүлэлтийг судалгаанд оролцсон хүүхдүүдийн амьдарч, сурч байгаа байршлаар, хүйсээр, суралцаж буй ангиар, насаар нь тус тус гарган өмнөх судалгааны буюу 2010, 2012 оны дүнтэй харьцуулсан байдлаар үзүүлэв (зураг 18-22).

Зураг 18. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Судалгаагаар хүүхдүүдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ 2013 онд өмнөх судалгаануудын дүнгээс нэмэгдсэн сайн үзүүлэлттэй буюу 2010 оныхоос 0.30 пункт, 2012 оныхоос 0.98 пунктээр тус тус нэмэгдсэн байна байна. Мөн байршлын хувьд ч өмнөх судалгааны дүнгээс нэмэгдсэн дүнтэй байна.

Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/




Дэд үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл 2013 онд мөн өмнөх судалгааны дүнгээс өссөн дүнтэй гарсан байна. 2010, 2012 оны судалгаагаар эрэгтэй хүүхдүүдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ эмэгтэй хүүхдүүдийнхээс өндөр гарч байсан бол энэ онд эмэгтэй хүүхдүүдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ эрэгтэй хүүхдүүдийнхээс өндөр байлаа.

Зураг 20. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/




Хууль ягштал сахих байдлын дэд үзүүлэлтийг суралцаж буй анги, насаар нь Зураг 21, 22-т үзүүлэв.

Зураг 21. Хүүхдийн хууль ягштал сахих дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/



Хүүхдийн хууль ягштал сахих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ нас болон суралцаж буй ангийн хувьд өмнөх судалгааны дүнгээс өссөн байна. Хүүхдүүдийн хууль ягштал сахих байдлын дэд үзүүлэлт 12 настай хүүхдүүдийн хувьд хамгийн өндөр буюу 3.98 гарсан байхад ангийн хувьд 8 болон 9 дүгээр ангид суралцаж буй хүүхдүүдийн хууль ягштал сахих байдал өндөр байв.

Зураг 22. Хүүхдийн хууль ягштал сахих дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/



3.4 Авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ


Хүүхдийн шударга байдал 2013 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих чадварыг хэмжих дэд үзүүлэлтийг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлов.

- Авлигыг үл тэвчих явдлыг танин мэдэхүй нь - Миний амьдралд сайнаар нөлөөлж байвал томчууд хууль зөрчиж болно. Энэ бол буруу зүйл биш.
- Авлигыг үл тэвчих явдалд нөлөөлөх нөлөөллийг-Шалгалтандаа хуулсан л бол сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх, ах эгчдээ хэлнэ.
- Авлигыг үл тэвчих явдлын илэрч буй зан үйл нь-Манай аав ээж, ах эгч төрийн байгууллагад ажилладаг. Тэд албан тушаалаа ашиглан баян болох нь буруу зүйл биш

Хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих явдлыг илэрхийлэх дэд үзүүлэлтийн бүлгийн дундаж үнэлгээ 3.35 гарсан нь сүүлийн судалгааны дүнгээс тогтмол буурах чиг хандлагатай байна.

Хүүхдийн шударга байдал 2013 судалгааны хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийг судалгаанд оролцсон хүүхдүүдийг сурч байгаа байршлаар болон хүйс, нас, суралцаж буй ангиар нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулсан байдлаар үзүүлэв (зураг 23-27).

Зураг 23. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ 2010 оноос хойш тогтмол буурч байгаа нь энэ хүрээнд цаашид томоохон алхам хийх шаардлагатай болсон байгааг харуулж байна. Тухайлбал, зарим улс оронд ерөнхий боловсролын сургуульд авлигын эсрэг хичээлийг орж, хүүхдүүдэд авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих байдлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.


Хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээг байршлаар нь авч үзвэл нийслэл болон аймгийн хүүхдүүдийнх 2013 онд өмнөх судалгаануудынхаас буурсан дүнтэй гарсан байна. Тухайлбал энэ онд 2012 оныхоос нийслэлийн хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ 0.85 пункт, аймгийн хүүхдүүдийнх 0.27 пунктээр буурсан байна

Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/




Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ хүйсийн хувьд сүүлийн жилүүдэд тогтмол бууралт ажиглагдаж байна. Тухайлбал, эрэгтэй хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ 2013 онд 3.34 гарч 2010 оныхоос 0.81 пункт, 2012 оныхоос 0.66 пунктээр муудсан болохыг илэрхийлж байна.

Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /хүйсээр/



Нас болон суралцаж буй ангийн хувьд авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ өмнөх судалгааныхаас мөн л буурсан байгааг Зураг 26, 27-д үзүүлэв.


Зураг 26. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /насаар/



Хүүхдийн шударга байдлыг хэмжиж буй 4 дэд үзүүлэлтийн хувьд авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийнх буурч, бусад 3 дэд үзүүлэлтийн үнэлгээ нэмэгдсэн байна. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ нас болон суралцаж буй ангийн хувьд сүүлийн судалгааны дүнгээс тогтмол буурсан дүнтэй гарсан байна. Насны хувьд 17 настай хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ хамгийн бага буюу 3.16 гарсан байхад

суралцаж буй ангийн хувьд 11 дүгээр ангийн хүүхдүүдийнх хамгийн бага буюу 3.22 гарсан байна.

Зураг 27. Хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ /ангиар/



ДҮГНЭЛТ

Монгол Улсын иргэн бидний ирээдүй, ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангид сурч буй 11-18 насны хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 2013 оны байдлаар 3.71 гарсан нь 2010 оныхоос 0.42 пункт, 2012 оныхоос 0.78 пунктээр өссөн байна.

Судалгаагаар хүүхдийн шударга байдлын түвшин өмнөх оныхоос 0.78 пунктээр нэмэгдэхэд авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ 0.49 пунктээр буурсан хэдий ч зан үйлийн зөв төлөвшилтийн үнэлгээ өмнөх оныхоос 1.07, ёс суртахууны үнэлгээ 1.59, хууль сахих байдлын үнэлгээ 0.98 пунктээр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 3.69, эмэгтэй хүүхдийнх 3.73 гарсан байгаа нь эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдээс илүү шударга байгаа нь харагдаж байна.

Судалгаанд 7 аймаг болон нийслэл Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулсан бөгөөд судалгааны үр дүнгээр шударга байдлын үнэлгээ нийслэл Улаанбаатар хотод 3.66, аймгуудынх 3.75 гарсан нь орон нутаг дахь /аймгийн/ хүүхдүүд Улаанбаатар хотын хүүхдүүдээс илүү шударга байна.

Судалгаанд эерэг өөрчлөлтүүд байгаа ч анхаарал хандуулах зарим асуудал байсаар байна. Тухайлбал, хүүхдүүд “Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй санал нийлж байна уу?” гэсэн асуултад 12.76 хувь нь бүрэн нийлж байна, нийлж байна гэж хариулсан бол 12.63 хувь нь эргэлзэж байна гэж хариулсан байгаа нь багшдаа бэлэг өгч дүнгээ ахиулах хандлагатай хүүхдэд

байгааг илэрхийлж байна. Мөн “Томчуудын хууль бус үйл ажиллагаа миний амьдралд сайнаар нөлөөлж байвал энэ нь буруу зүйл биш гэдэгтэй санал нийлж байна уу?” гэсэн асуултад хүүхдүүдийн 21.13 хувь нь эргэлзэж байна, 17.88 хувь нь нийлж байна, бүрэн нийлж байна гэж хариулсан байна.

Мөн түүнчлэн “Шалгалт өгөхдөө хуулсан бол тэр хүн нь миний сайн найз байсан ч энэ тухай багш, дотнын хүндээ мэдэгдэнэ гэдэгтэй санал нийлж байна уу?” гэсэн асуултад хүүхдүүдийн 72.01 хувь нь санал огт нийлэхгүй, нийлэхгүй, эргэлзэж байна гэж хариулсан байна. “Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь мэдэгдэнэ гэдэгтэй санал нийлж байна уу?” гэсэн асуултад эргэлзсэн, нийлэхгүй болон огт нийлэхгүй байгаа хүүхдийн хувь мөн л 28,13 хувийн эзэлж байгаа зэргийг цаашид анхаарах шаардлагатай байна.

САНАЛ

Судалгаагаар ерөнхий үнэлгээ сайжирсан үзүүлэлттэй байгаа ч зарим үзүүлэлтийн хувьд анхаарал хандуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл шударга бус явдалтай санал нийлж байгаа болон эргэлзэж байгаа хүүхдүүд байсаар байгаа нь тэдний шударга ёсны ойлголт, зарчим, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, улмаар авлигын хор хөнөөл, үр дагаврыг таниулах, шударга ёсыг амьдралдаа баримтлах зарчим болгон төлөвшүүлэх зэрэг шаардлага байна. Иймд судалгааны үр дүнд тулгуурлан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд шударга ёс, авлигын эсрэг боловсрол олгох агуулгатай хичээлийг нэмж тусгах талаар Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран ажиллах;
- Шударга ёсны тухай аудио, электрон ном, гарын авлага, сургалтын материал боловсруулан туршиж, нэвтрүүлэх;
- Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, шударга зан үйлийг урамшуулан дэмжих чиглэлээр хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлөх нийтлэл, нэвтрүүлгийн давтамжийг нэмэгдүүлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 41 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм”-ийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэх, уг дүрэмд багш бэлэг, хандив авах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тодорхой тусгах;
- Багш, эцэг эх, анги хамт олны дунд шударга ёс, ёс зүйгээ эрхэмлэн сахигч, бусдад үлгэр дуурайл болох багш, эцэг эх, сурагчийг Хүүхдийн төлөө газартай хамтран тодруулж, сурталчлах.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1: Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

д/д			Дэд үзүүлэлт	Үнэлгээ		
				2010	2012	2013
1.1	Ёс суртахуун	Танин мэдэхүй	Сурагчид гэрийн даалгавраа хийхдээ интернэт болон бусад хүмүүсийн бичсэн зүйлийг хуулчихаад багшдаа би бичсэн гэж хэлэх нь буруу зүйл биш	3.20	2.72	3.66
1.2		Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал	2.70	2.49	3.91
1.3		Зан үйлийн	Урт дараалалд хүлээж байснаас урдуур дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ	3.20	2.99	3.82
Ёс суртахуун-Бүлгийн дундаж				3.03	2.73	3.80
2.1	Зөв төлөвшил	Танин мэдэхүй	Ангийн дарга болохын тулд ангийхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш	2.20	1.85	3.99
2.2		Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга	2.20	1.94	4.08
2.3		Зөв төлөвшлийн	Авлига авсан, хулгай хийсэн, хүн зодсон гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.	3.10	3.10	3.57
Зөв төлөвшил - Бүлгийн дундаж				2.51	2.29	3.88
3.1	Хууль ягштал сахих	Танин мэдэхүй	Миний найз шалгалтандаа хуулах нь буруу зүйл биш	4.42	3.61	3.63
3.2		Нөлөөллийн	Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно.	3.40	2.96	4.02
3.3		Зан үйлийн	Ойр хавьд цагдаа байхгүй дохиолдолд би хууль сахихыг хичээхгүй	2.80	1.98	3.83
Хууль ягштал сахих-Бүлгийн дундаж				3.54	2.85	3.83
1	Авлигыг үл тэвчих	Танин мэдэхүйн	Томчуудийн хууль бус үйл ажиллагаа миний амьдралд сайнаар нөлөөлж байвал энэ нь буруу зүйл биш	2.70	2.34	3.69
2		Нөлөөллийн	Шалгал тандаа хуулсан л бол миний сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх дотнын хүндээ хэлнэ.	6.71	6.23	2.73
3		Зан үйлийн	Миний гэр бүлийн гишүүд төрийн албан тушаалаа ашиглаж хууль зөрчин баян болох нь буруу зүйл биш	2.90	2.97	3.65
Авлигыг үл тэвчих- Бүлгийн дундаж				4.10	3.84	3.35

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн асуултад хариулсан байдал дүнд эзлэх хувиар

Асуулт/Хариулт	ОГТ нийлэхгүй	Нийлэхгүй	Эргэлзэж байна	Нийлж байна	Бүрэн нийлж байна	Дун
Таны сайн найз шалгалтандаа хуулах явдал буруу зүйл биш гэдэгтэй та санал нийлж байна уу?	30.38	27.38	23.00	13.13	6.13	100.0
Томчуудын хууль бус үйл ажиллагаа миний амьдралд сайнаар нөлөөлж байвал энэ нь буруу зүйл биш гэдэгтэй та санал нийлж байна уу?	30.25	30.75	21.13	13.00	4.88	100.0
Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернэт болон хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш гэдэгтэй санал нийлж байна уу?	29.75	33.38	16.38	14.00	6.50	100.0
Ангийн даргын сонгуульд ажилд ялахын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш гэдэгтэй та санал нийлж байна уу?	38.50	36.50	12.88	9.63	2.50	100.0
Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй та санал нийлж байна уу?	48.50	26.13	12.63	10.13	2.63	100.0
Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл гэдэгтэй та санал нийлж байна уу?	37.63	30.25	20.75	8.63	2.75	100.0
Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно гэдэгтэй та санал нийлж байна уу?	43.38	30.88	14.38	7.50	3.88	100.0
Шалгалтандаа хуулсан бол тэр хүн нь миний сайн найз байсан ч энэ тухай багш, дотнын хүндээ мэдэгдэнэ. Та үүнтэй санал нийлэх үү?	18.88	25.88	27.25	19.38	8.63	100.0
Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ. Та үүнтэй санал нийлэх үү?	32.50	36.00	15.50	12.75	3.25	100.0
Цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм сахицыг хичээхгүй. Та үүнтэй санал нийлэх үү?	35.25	31.13	20.13	8.00	5.50	100.0
Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь мэдэгдэнэ. Та үүнтэй санал нийлж байна уу?	8.88	13.75	15.50	35.50	26.38	100.0
Миний гэр бүлийн гишүүд төрийн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш гэдэгтэй санал нийлж байна уу?	31.75	27.88	21.38	11.13	7.88	100.0